

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Манлай сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2025/027/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр
Өмнөговь аймаг	Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn
2025 он	Аудитын менежер: Т.Хонгорзул
	Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn
	Ахлах аудитор: Б.Алтанцэцэг
	Утас: 8000-7121 Цахим хаяг: tolinetugen@gmail.com
	Толин этүгэн аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Б.Отгон-Өлзий
	Утас: 99844655 Цахим хаяг: otgon1118@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

МАНЛАЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Н.ГАНТӨМӨР ТАНАА

2025.02.25 № 80
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Манлай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Өмнөговь аймгийн хэмжээнд хэрэгжиж буй нутгийн дэм хөтөлбөрт албан хаагчдыг, зургаадугаар ангийн сурагчдыг үдийн хоол хөтөлбөрт хамруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Өмнөговь аймгийн хөрөнгө оруулалтаар “Боловсрол Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд 1,283.2 мянган төгрөгийн дотуур байрны хяналтын камерын дагалдах хэрэгсэл, Даланзадгад сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 97,450.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 7 зорилт, 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Досх
4625020190

хэрэгжилтийг 87.4 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/мянган төгрөгөөр/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.	
Санхүүгийн байдлын тайлан			
Эргэлтийн хөрөнгийн дүн	180,467.2	289,577.8	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,558,834.9	6,483,106.2	
Нийт хөрөнгийн дүн	6,739,302.1	6,772,684.0	
Нийт өр төлбөрийн дүн	-	-	
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,739,302.2	6,772,684.0	
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,739,302.2	6,772,684.0	
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
Үйл ажиллагааны орлогын дүн	1,577,912.9	2,490,033.1	
Үйл ажиллагааны зардлын дүн	1,710,306.2	2,448,219.5	
Үйл ажиллагааны үр дүн	(132,393.3)	41,813.6	
Үйл ажиллагааны бус үр дүн	(76,065.00)	(8,431.80)	
Үйл ажиллагааны нийт үр дүн	(208,458.30)	33,381.80	
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,376,334.5	6,739,302.2	
Тайлант оны үр дүн	362,967.7	33,381.8	
Эцсийн үлдэгдэл	6,739,302.2	6,772,684.0	
Мөнгөн гүйлгээний тайлан			
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,522,623.5	2,315,921.1	
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,474,420.4	2,177,555.6	
Үйл ажиллагааны ЦМГ	48,203.1	138,365.5	
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(14,934.4)	(39,269.0)	
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-	
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	33,268.7	99,096.5	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	51,177.9	84,446.6	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	84,446.6	183,543.1	
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,316,103.4	2,216,293.8	
Урсгал зардал	2,316,103.4	2,216,293.8	
Хөрөнгийн зардал	-	-	
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	2,316,103.4	2,313,175.6	
Улсын төсвөөс санхүүжих	1,554,381.3	1,554,334.5	
Орон нутгийн төсвөөс	398,620.2	397,089.3	
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	363,101.9	361,751.8	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн 349.8 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.

- Үр дүнгийн тайланд улсын төсвийн санхүүжилтээр худалдан авсан хөрөнгийг нэмж тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг цэвэрлээгүй,
- Програмын элэгдэл 1.550.0 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үр дүнгийн тайланд улсын төсвийн санхүүжилтээр худалдан авсан хөрөнгийг нэмж тайлагнасан.	1.0	39,269.0			1.0	39,269.0	1.0	39,269.0				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх жилжүүлгийг цэвэрлээгүй	1.0	530.8			1.0	530.8	1.0	530.8				
Программын элэгдэл 1.550.0 мянган төгрөгийн элэгдэл тооцоогүй байна.	1.0	1,550.0	1.0	1,550.0			1.0	1,550.0				
Дүн	1.0	41,349.8	1.0	1,550.0	2.0	39,799.8	3.0	41,349.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хяналтын байгууллагад шилжүүлсэн			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Нийт											-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								